**ЭМЭЭЛТИЙН ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ ДАРГЫН ТУШААЛ**

2016 оны 06 сарын 10 өдөр Дугаар А/48 Улаанбаатар хот

# Томилолтоор ажиллуулах тухай

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 149 дүгээр тогтоолын хавсралт "Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн, үйлдвэрлэл технологийн парк" орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.8 дах заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол улсын Засгийн газрын 2013 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 394 дүгээр тогтоолоор Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан малчин, мал бүхий иргэдэд олгож буй мөнгөн урамшууллын түүхий эдийн чанарт нөлөөлөх нөлөөллийг хамгийн олон малтай аймгийн сумдад түүвэр судалгаа хийх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч

| | |
|---|---|
| Ерөнхий инженер бөгөөд барилгын инженер | Г.Пүрэвдорж |

Ажлын хэсгийн гишүүд

| | |
|---|---|
| Хөнгөн үйлдвэрийн технологич инженер | М.Баярсүрэн |
| Үйл ажиллагааны төлөвлөлт хариуцсан эдийн засагч | С.Ариунбилэг |

2. Ажлын хэсгийг 2016 оны 06 дугаар сарын 13-аас 16-ны хооронд Архангай аймагт ажиллахыг зөвшөөрсүгэй.
3. Ажлын хэсгийн Улаанбаатар – Архангай – Улаанбаатар маршрутын 1700 км зам туулахад шаардагдах 340л түлшний үнэ 544,000 төгрөгийг тээвэр шатахууны зардлаас санхүүжүүлэхийг Нягтлан бодогч Г.Батнямд зөвшөөрсүгэй.
4. Ажлын хэсгийн тайланг 2016 оны 06 дугаар сарын 20-ны дотор танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч Г.Пүрэвдоржид үүрэг болгосугай.
5. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн А.Нямхүүд даалгасугай.

УЛААНБААТАР ХОТ ЭМЭЭЛТИЙН ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ ТТТ2340 ☎ 8161709

ДАРГА М.ГОНЧИГЖАВ

3150600048